

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ2019 оны ... дүгээр
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Аргачлал шинэчлэн батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6, 9 дүгээр зүйлийн 9.1.18 дахь заалт, Эрчим хүчний зохицуулах хорооны дүрмийн 2 дугаар зүйлийн 2.1.2, 5 дугаар зүйлийн 5.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос **ТОГТООХ нь:**

1. “Эрчим хүчний зохицуулалтын үйлчилгээний хөлс тооцох аргачлал”-ыг хавсралтын ёсоор шинэчлэн баталсугай.
2. Батлагдсан аргачлалын дагуу жил бүр Хорооны төсвийг бүрдүүлж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар /М.Мөнхтулга/-т үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Г.Эрхэмбаяр/-д даалгасугай.
4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны “Аргачлал шинэчлэн батлах тухай” 2018 оны 193 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

А.ТЛЕЙХАН

ЗОХИЦУУЛАГЧ

Б.БАТТУЛГА

ЗОХИЦУУЛАГЧ

У. МЯГМАРСҮРЭН

ЗОХИЦУУЛАГЧ

Б.АМАРСАНАА

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС ТООЦОХ АРГАЧЛАЛ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Энэхүү аргачлалын зорилго нь Эрчим хүчний зохицуулах хороо (цаашид Хороо гэх)-ны үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлын төсвийг бүрдүүлж буй эрчим хүчний зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг зүй зохистой тогтооход оршино.
- 1.2. Хороо нь Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.18 дахь заалтыг үндэслэн эрчим хүчний зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох ба тусгай зөвшөөрөл эзэмшигчдийг үл ялгаварлана.
- 1.3. Эрчим хүчний зохицуулалтын үйлчилгээний хөлсний нийт хэмжээ нь Хорооны тухайн жилийн батлагдсан үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлын төсвийг хангахуйц байна.
- 1.4. Эрчим хүчний зохицуулалтын үйлчилгээний хөлс нь тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон болон тусгай зөвшөөрөл эзэмшигчид үзүүлсэн зохицуулалтын үйлчилгээний хөлснөөс бүрдэнэ.
- 1.5. Эрчим хүчний зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тусгай зөвшөөрлийн төрөл, хүчин чадал, үйл ажиллагаа эрхлэх хугацаа, үйл ажиллагааны орлого зэргийг харгалзан тогтооно.

Хоёр. Тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон зохицуулалтын үйлчилгээний хөлс

- 2.1. Тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон зохицуулалтын үйлчилгээний хөлсийг эрхлэх үйл ажиллагааны төрөл, тусгай зөвшөөрлийн хугацаанаас хамааруулан дараах томъёоны дагуу тооцох ба уг зохицуулалтын үйлчилгээний хөлсний доод хэмжээ буюу суурь хөлс нь 250.0 /Хоёр зуун тавин/ мянган төгрөг байна.

- 2.1.1. Цахилгаан үйлдвэрлэх:

$$T_{цү} = C + (Ч - 5) \times T_{хч} \times K_t$$

$T_{цү}$ - Тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ; (суурилагдсан хүчин чадлын хэмжээ 5 МВт-аас дээш бол)

C - Суурь хөлс; 250.0 /Хоёр зуун тавин/ мянган төгрөг

$Ч$ - Суурилагдсан хүчин чадал; МВт;

$T_{хч}$ - Нэг МВт чадлын хөлс; 30.0 /Гучин/ мянган төгрөг;

K_t - Тусгай зөвшөөрлийн хугацаанаас хамаарсан коэффициент;

2.1.2. Дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх:

$$T_{\partial y, \partial m} = C + (Ч : 0.86 - 5) \times T_{xч} \times K_t$$

$T_{\partial y, \partial m}$ - Тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ; (суурилагдсан хүчин чадлын хэмжээ 8.6 Гкал/ц-аас дээш бол)

C - Суурь хөлс; 250.0 /Хоёр зуун тавин/ мянган төгрөг

$Ч$ - Суурилагдсан хүчин чадал; Гкал/ц;

$T_{xч}$ - Нэг МВт чадлын хөлс; 30.0 /Гучин/ мянган төгрөг;

K_t - Тусгай зөвшөөрлийн хугацаанаас хамаарсан коэффициент;

2.1.3. Цахилгаан дамжуулах, түгээх:

$$T_{цд, цт} = C + (Ч - 5) \times T_{xч} \times K_t$$

$T_{цд, цт}$ - Тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ; (суурилагдсан хүчин чадлын хэмжээ 5 МВА - аас дээш бол)

C - Суурь хөлс; 250.0 /Хоёр зуун тавин/ мянган төгрөг

$Ч$ - Суурилагдсан хүчин чадал; МВА;

$T_{xч}$ - Нэг МВА чадлын хөлс; 30.0 /Гучин/ мянган төгрөг;

K_t - Тусгай зөвшөөрлийн хугацаанаас хамаарсан коэффициент;

2.1.4. Цахилгаанаар зохицуулалттай, зохицуулалтгүй хангах, цахилгаан импортлох, цахилгаан экспортлох:

$$T_{цэх, ци, цэ} = C + (Э_c : 8640 - 5) \times T_{xч} \times K_t$$

$T_{цэх, ци, цэ}$ - Тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ; (эрчим хүчний хэмжээ 1 жилд 43200 мян.кВтц-аас дээш бол)

C - Суурь хөлс; 250.0 /Хоёр зуун тавин/ мянган төгрөг

$Э_c$ - Тусгай зөвшөөрөл хүсэгчийн төлөвлөж буй борлуулах, импортлох, экспортлох цахилгааны хэмжээ; мян.кВт.ц;

T - Нэг МВт чадлын хөлс; 30.0 /Гучин/ мянган төгрөг;

K_t - Тусгай зөвшөөрлийн хугацаанаас хамаарсан коэффициент;

2.1.5. Дулаанаар зохицуулалттай, зохицуулалтгүй хангах:

$$T_{дэх} = C + (Э_d : 0.86 : 5630 - 5) \times T_{xч} \times K_t$$

$T_{дэх}$ - Тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ; (эрчим хүчний хэмжээ 1 жилд 28150 Гкал-аас дээш бол)

C - Суурь хөлс; 250.0 /Хоёр зуун тавин/ мянган төгрөг

$Э_d$ - Тусгай зөвшөөрөл хүсэгчийн төлөвлөж буй борлуулах дулааны хэмжээ; Гкал;

T - Нэг МВт чадлын хөлс; 30.0 /Гучин/ мянган төгрөг;

K_t - Тусгай зөвшөөрлийн хугацаанаас хамаарсан коэффициент;

2.1.6. Диспетчерийн зохицуулалт хийх:

$$T_{\text{дп}} = C \times t$$

$T_{\text{дп}}$ - Тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;

C - Суурь хөлс; 250.0 /Хоёр зуун тавин/ мянган төгрөг

t – Тусгай зөвшөөрлийн хугацаа

2.1.7. Хийгээр хангах:

$$T_{\text{хх}} = C + \frac{Q_{\text{H}}^{\text{P}} * \rho * V}{0.86 * 10^6} * T_{\text{чх}} * K_{\text{t}}$$

$T_{\text{хх}}$ – Тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;

C - 250.0 /Хоёр зуун тавин/ мянган төгрөг

V - Тусгай зөвшөөрөл хүсэгчийн хангахаар төлөвлөж буй хийн хэмжээ; м³;

ρ - Шингэрүүлсэн хийн нягт; кг/м³;

$T_{\text{чх}}$ - Нэг МВт чадлын хөлс; 30.0 /Гучин/ мянган төгрөг;

K_{t} - Тусгай зөвшөөрлийн хугацаанаас хамаарсан коэффициент;

2.1.8. Эрчим хүчний барилга, байгууламж барих:

$$T_{\text{мз}} = C + Ч \times T_{\text{чх}} \times K_{\text{t}}$$

$T_{\text{мз}}$ - Тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;

C - Суурь хөлс; 25,000.0 мянган төгрөг;

$Ч$ - Эх үүсвэрийн суурилагдсан хүчин чадал; МВт;

$T_{\text{чх}}$ - Нэг МВт чадлын хөлс; 30.0 /Гучин/ мянган төгрөг;

K_{t} - Тусгай зөвшөөрлийн хугацаанаас хамаарсан коэффициент;

2.1.9. Эрчим хүчний эх үүсвэр /үүсгүүр/-ийн хүчин чадлыг өөрчлөх, Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах:

$$T_{\text{мз}} = Ч \times T_{\text{чх}} \times K_{\text{t}}$$

$T_{\text{мз}}$ - Тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;

$Ч$ - Хүчин чадлын өөрчлөгдөх хэмжээ; МВт; Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах бол эх үүсвэрийн суурилагдсан хүчин чадал; МВт;

$T_{\text{чх}}$ - Нэг МВт чадлын хөлс; 30.0 /Гучин/ мянган төгрөг;

K_{t} - Тусгай зөвшөөрлийн хугацаанаас хамаарсан коэффициент;

2.1.10. Цахилгаан, дулаан дамжуулах, түгээх шугам, дэд станц, дулаан дамжуулах төв барих:

№	Эрчим хүчний барилга байгууламжийн төрөл	Хүчин чадал	Хөлсний хэмжээ /мян.төг/
1	Цахилгаан дамжуулах, түгээх шугам, дэд станц барих	35 кВ ба түүнээс доош	3,000.0
		110 кВ	7,000.0
		220 кВ	10,000.0
		330 кВ ба түүнээс дээш	15,000.0
2	Дулаан дамжуулах, түгээх шугам, дэд станц барих	16кгх/см2, 350-500ф	1,000.0
		16кгх/см2, 500-700ф	3,000.0
		16кгх/см2, 700-1200ф	5,000.0

- 2.2. Энэ аргачлалын 2.1.1-2.1.9-д заасан томъёоны К коэффициентийг дараах томъёогоор тооцно.

$$K=1+(0.1 \times \text{тусгай зөвшөөрлийн хугацаа; жил})$$

- 2.3. Эрчим хүчний барилга, байгууламж барих хугацааг сунгахаас бусад тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах бол энэ аргачлалын 2.1.1-2.1.7 -д заасан томъёоны дагуу зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тооцно.
- 2.4. Тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтнүүд тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой улсын тэмдэгтийн хураамж болон зохицуулалтын үйлчилгээний хөлсний тухай холбогдох хууль, аргачлалын заалтыг сонирхогч хуулийн этгээдэд урьдчилж танилцуулна.
- 2.5. Тусгай зөвшөөрөл олгох шийдвэр гарвал Хорооны тогтоолыг үндэслэн, ажлын 3 хоногийн дотор хариуцсан мэргэжилтнүүд хавсралт №1-д заасаны маягтаар мэдээллийг гаргаж, нэгжийн даргаар хянуулан санхүүд өгнө.
- 2.6. Санхүү нь тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг аргачлалын дагуу тооцон, тусгай зөвшөөрөл эзэмшигчээс нэхэмжлэх ба Хорооны тогтоолоор баталгаажуулна

Гурав. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид үзүүлсэн зохицуулалтын үйлчилгээний хөлс

- 3.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид үзүүлсэн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс тооцон авна.
- 3.2. Цахилгаан, дулаан хослон үйлдвэрлэх, цахилгаан, дулаан дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, цахилгаан импортлох, экспортлох, эрчим хүчээр зохицуулалттай болон зохицуулалтгүй хангах, хийгээр хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчид үзүүлсэн зохицуулалтын үйлчилгээний хөлс:

$$T_{3y1} = O_{ya1} \times K_1$$

T_{3y1} - Тусгай зөвшөөрөл эзэмшигчид үзүүлсэн зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;

O_{ya1} – Энэ аргачлалын 3.2-т заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааны орлого буюу борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ;

K_1 - Зохицуулалтын үйлчилгээний хөлс тооцох коэффициент; Хорооны тухайн жилийн батлагдсан төсвийн дүнгээс өмнөх оны тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг хассан дүнг, энэ аргачлалын 3.2-т заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны тухайн оны орлого буюу борлуулалтын орлогын шаардагдах хэмжээний нийлбэр дүнд хувааж гаргана;

- 3.3. Дулаан үйлдвэрлэх (дангаар) тусгай зөвшөөрөл эзэмшигчид үзүүлсэн зохицуулалтын үйлчилгээний хөлс:

$$T_{3y2} = O_{ya2} \times K_2$$

T_{3y2} - Тусгай зөвшөөрөл эзэмшигчид үзүүлсэн зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;

$O_{\gamma a2}$ – Энэ аргачлалын 3.3-т заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааны орлого буюу борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ;

K_2 - Зохицуулалтын үйлчилгээний хөлс тооцох коэффициент; Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлүүдийн үйл ажиллагаатай холбогдон Хорооноос санхүүжүүлэх зардлын төсвийн дүнг 3.3-т заасан (Дулаан үйлдвэрлэх) тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны орлого буюу борлуулалтын орлогын шаардагдах хэмжээний нийлбэр дүнд хуваана;

- 3.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид үзүүлсэн зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тооцох тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааны орлого буюу борлуулалтын орлогын шаардагдах хэмжээг хавсралт №2-т заасны дагуу үнэ тарифын мэргэжилтнүүд гаргаж нэгжийн даргаар, хянуулан, санхүүд өгнө.
- 3.5. Тухайн жилийн үйл ажиллагааны зардал, хөрөнгө оруулалтын төсвийг санхүүжүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг 3.2; 3.3-т заасны дагуу тооцон, Хорооны тогтоолоор баталгаажуулан тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс нэхэмжилнэ.

————oOo————

20.. ОНД ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР АВСАН, СУНГУУЛСАН
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

20.. оны ... сарын ... ны өдөр

№	Компанийн нэр, регистрийн дугаар	Шинээр олгосон, сунгасан аль нь болох	Тусгай зөвшөөрөл олгосон огноо	Тогтоолын дугаар	Тусгай зөвшөөрлийн төрөл	Суурилагдсан хүчин чадал /МВт, Гкал/цаг, МВА/	Хангах, импортлох, экспортлох эрчим хүчний хэмжээ /мян.кВт.ц, Гкал/	ТЗЭ-ийн утасны дугаар

Жич: Тогтоолын хуулбарыг хавсаргана.

Хянасан:

Тусгай зөвшөөрөл хариуцсан нэгжийн дарга

/...../

Бэлтгэсэн:

Тусгай зөвшөөрлийн мэргэжилтэн

/...../

Хүлээн авсан:

Ахлах нягтлан бодогч

/...../

Хавсралт №2

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН 20... ОНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО БУУ БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ШААРДАГДАХ ХЭМЖЭЭ

20.. оны ... сарын ... ны өдөр

№	Компанийн нэр, регистрийн дугаар	Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны орлого буюу БОШХ /мянган төгрөг/

Хянасан:

Үнэ тариф хариуцсан нэгжийн дарга

/...../

Бэлтгэсэн:

Үнэ тарифын мэргэжилтэн

/...../

Хүлээн авсан:

Ахлах нягтлан бодогч

/...../